

**Манж, монгол хэлний урт эгшгийг язгуур дүйх үгсийн
хүрээнд харьцуулах нь**

Э. Мөнх-Учрал
(МУИС)

Манж, монгол хэл нь нэг овгийн хэл болохын хувьд адил төсөөтэй, таарч тохирох зүйл олонтаа ажиглагддаг билээ. Энэ удаад бид, тус хоёр хэлний язгуур дүйх үгсийн бүтэц дэх урт эгшгийн байдлыг харьцуулан үзэхийг хичээе. Ингэх нь, тэдгээр үгсийг хэрэв хоёр хэлний дундын үг ахул өвөг эртний хэлбэрээс хэрхэн мөчирлөн хувьссан, ормол үг бол хэдий үеийн хэлний нөлөөлөл байж болох хийгээд манж, монгол хэлний авианы хууль дахь нийтлэг ба онцлог шинжийг тодруулахад тус нэмэр болох юм.

Авианы түүхэн хувьслын үр дүнд бий болсон орчин цагийн монгол хэлний үүсмэл урт эгшгийг А. А. Бобровников¹ анхлан хэл шинжлэлийн үүднээс тайлбарласнаас хойш олон эрдэмтэн судлан үзэж өөр өөрийн зохих дүгнэлтийг өгсөн бөгөөд эдгээрийг:

- Гол төлөв хоёр эгшгийн хоорондох "γ/g/y" гийгүүлэгч аажимдаа гээгдэж, хоёр этгээдийн эгшиг нийлсний улмаас урт эгшиг үүссэн²;
- Хоёр эгшгийн хоорондох ү, ɣ гийгүүлэгчийн арын эгшиг нь өргөлттэй байсан бөгөөд өргөлтөөс сунжран үүссэн урт эгшгийн нөлөөгөөр өмнөх гийгүүлэгч нь сулран суларсаар сугарсан³ гэж ерөнхийлөн багцалж болно.

Үүсмэл урт эгшиг бүрэлдэн тогтсон цаг хугацааны хувьд эрдэмтдийн санал харилцан адилгүй боловч багцаагаар эртний монгол хэлний сүүлч үеэс бие даасан урт эгшиг болж урт, богиноороо эсрэгцэн утга ялгах болжээ.

Монгол хэлний урт эгшиг нэлээд сайн судлагдсан бөгөөд манж судлалын эрдэмтэд ихэвчлэн үгийн язгуур талыг хөндсөн нь давуу хэдий ч И. Захаров⁴, Л. Мишиг⁵, К. Меллес⁶, И.

¹ А. А. Бобровников, *Грамматика монгольско-калмыцкого языка*, Казань, 1849.

² Г. И. Рамстедт, *Сравнительная фонетика Монгольского письменного языка и халхаско-ургинского говора*, Санктпетербург, 1908; Б. Я. Владимирцов, *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Введение и фонетика*, Ленинград, 1929; Г. Д. Санжеев, *Сравнительная грамматика монгольских языков. Том 1*, Москва, 1953; N. Poppe, *Introduction to Mongolian Comparative Studies*, Helsinki, 1955.

³ Sh. Hattori, *The length of Vowels in Proto Mongolian*, *Mongolian Studies*, Budapest, 1970; N. Poppe, *On the Velar stops in Intervocalic Position in Mongolian*, *Ural-Altische Jahrbücher*, Wiesbaden, 1959, *The Primary Long Vowels in Mongolian*, *Journal de la Société Finno-Ougrienne*, Helsinki, 1962; Ш. Лувсанвандан, *Орчин цагийн монгол хэлний урт эгшгийн гарлын тухай асуудалд*, Хэл зохиол 4, 1966.

⁴ И. Захаров, *Грамматика маньчжурского языка*, Санктпетербург, 1879.

⁵ Л. Мишиг, *Манжийн дусал бинтгүй үсгийн бичгийн тухай*, МУИС, ЭШБ VII б., 1964.

⁶ Cornélie H. Melles, *Un vocabulaire du mandchu préclassique le Tongki fuqa aqo xergen-I bitxe*, *Acta Orientalia*, Tom. XXIX, fasc.3, 1975.

Цинциус⁷ нарын эрдэмтэн тодорхой жишээгээр манж хэлний авиан зүйн асуудалд анхаарлаа хандуулж зохиол бүтээлээ туурвижээ.

Манж хэлэнд язгуур дүйх монгол хэлний үүсмэл урт эгшиг бүхий үгс:

ааль	мо. aγali, ма. ageli
адуу	мо. aduyu, ма. adun, эвенк. абду, эвен. абдү, нег. абдүн, орок. абдү, сол. адү
араа	мо. aray-a < *ariga, ма. argan < *aragan эвенк. арай < мо.
ачаа	мо. ačiy-a ~ ačiy-a, ма. ačiha, эвенк. атига < мо., бур. аша
байцаа-	мо. bayičay-a-, ма. baiča-, сол. бауса-, нег. байта-, орок. баута-, үд. баута-, ульч. байта-, орооч. баута-~байта-, нан. байта-, бур. байсаа-
бараа	мо. baray-a, ма. baran
баатар	мо. bayatur, ма. baturu, эвенк. багади, сол. бәтар, эвен. баүтир, орок. бәту, нан. бәтор, як. бәтыр~бөтур, ульч. бәтүр
битүү	мо. bitegüü, ма. butu, эвенк. бутү < мо.
боодол	мо. boγudul, ма. bofon, ульч. бану(н-), орок. бану(н-), нан. бапо
болзоо	мо. boljuγ-a, ма. boljon, эвенк. *bolžog
будаа	мо. buday-a, ма. buda, нег. буда, орок. бұда~бүдда, ульч. буда, нан. бода
буруул-	мо. buruyula-, ма. burula- < мо., сол. бұрүлā- < мо.
буурал	мо. buyurul, ма. burulu(morin), эвенк. бурул, эвен. бұрно, як. булур, сол. ббрал < мо., орок. болó, чув. рь*въrla, даг. bōral, bōlai
бүдүүн	мо. бүдүгүн, ма. bedun, эвенк. будунь, даг. budün, дунш. biedun, як. бөдөн
бүлээн	мо. бүлийен, ма. buluqan, эвенк. булди < мо., сол. булдитти < мо., үд. буги, нан. бул бй, зөр. püh-lü-wēn
бүрээ	мо. бүриγ-е, ма. buren < мо., нан. бурэ < ма.
бүрээс	мо. бүриγесү, ма. burgiyen
бэргэн	мо. bergen~berigen, ма. berhu < мо., эвенк. бэригэj < мо., як. бәргән~мәргән
бээр-	мо. begere-, ма. beye-, эвенк. бэүи-, эвен. бэй-~бэји-, ульч. бэй-~бэји-, нег. бэйү-, зөр. реi-, нан. бэй-бэји
гацаа	мо. γačay-a, ма. γačan, нег. гасиң орооч. гаса, ульч. гаса(н-), орок. гаса, нан. гас'а,
гашуун	мо. γasiyun, ма. γasihon, эвенк. гоци, эвен. гот, нег. готигди, орок. готти, нан. гочи, орооч. готиси
гөрөөс	мо. gögügesü, ма. gurgu
гүзээ	мо. güjige, ма. guwejihe, эвенк. гудигэ, сол. гудэгэ, эвен. гуди, нег. гуди, үд. гудиз, нан. гүжэ
гүү	мо. gegüü, ма. geu, эвенк. гэү < мо., сол. гэү, ям. кй
гутаа-	мо. γutuγ-a-, ма. γutu-
гэгээн	мо. gegegen, ма. genggiyen, ульч. гэгзэ(н-), орок. гэгүэн, нан. гэнгиэ
даваа	мо. dabay-a, ма. dabayan, эвенк. даван, ульч. даба, орооч. дава, нан. даба, орок. давак у
дайр-	мо. dayari-, ма. дари-, сол. дāри-, нан. дар'а-
дүү	мо. degüü, ма. deu < мо., сол. доу~д++ < мо., нан. дэу < ма. < мо.
дэгээ	мо. degege, ма. dehe, эвенк. дэгэ < мо., орооч. дā
дээж	мо. degeji, ма. deji, эвенк. дөжи~дожи < мо.
дэлүү	мо. deligüü, ма. delihun, эвенк. дэлкин, сол. дэлкй, үд. дэлиги
заар	мо. jayar~jiyar, ма. jarin, сол. жār
завшаан	мо. jabsiyan, ма. jabšan
зөө-	мо. jögege-, ма. juwe-, эвенк. жүү-, эвен. жүγ-, орооч. жүги-, орок. дүри-, үд. жү-, жүги-
зээр	мо. jeger-e, ма. jeren < мо., сол. жигрэ~жэгэрэ < мо., үд. жэли
зээрд	мо. jegerde, ма. jerde, эвенк. жэрдэ < мо., сол. жэрдэ < мо.
жороо	мо. jiguγ-a, ма. juran, эвенк. жирэ, эвен. жөрдүн, нан. жоаранда, як. жоруо

⁷ И. Цинциус, *Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков*, Ленинград, 1975.

жолоо	мо.jiluy-a, ма.jilhū
илүү	мо.ilegūū, ма.fulu, эвенк.һэлэкэ, сол.улэх, эвен.һулэк, нег.хулэхэ, хулэчэ, ороch.хулэ, үд.хул'а, ульч.пулэ, орок.пуллэ~пулэ, пулэуэ, нан.пулэ
инээ-	мо.inīye-, ма.inje-, эвенк.ин'э-, сол.нэктэ-, эвен.ин'-, нег.ин'э-, ороch.ин'эктэ-, үд.ин'э-, ульч.ин'эктэ-, нан.нэктэ-
маалинга	мо.mayalingyu, ма.malangyu
ногоон	мо.noγuyan, ма.niowanggiyan, эвенк.noγōn<мо., сол.нахун, ороch.нолиги, үд.н'олиуи, ульч.н'огзо(н-), орок.н'огдо, нан.н'ojra
нүү-	мо.negū-, ма.neu-, эвенк.нулги-, эвен.нүд-/з-, сол.нүлги-, нег.нулги-, ульч.н'улзи-, орок.нулди- ~нулзи-, нан.нуктэ-
нээ-	мо.nege-, ма.nei-, эвенк.нй̄, нег.нй̄-, ороch.н'й̄, үд.нй̄ги-, ульч.н'й̄-~нй̄зи-, орок.н'й̄-, нан.н'ихэли-
овоо	мо.obuγ-a, ма.obo<мо., хам.оба
ооно	мо.oγuni, ма.onun<мо.
рашаан	мо.arasiyan~rasiyan<скp., ма.arašan<мо.<скp.gasayana
сайр	мо.sayari, ма.sarin, эвенк.cāpий̄ <як., сол.cāp<мо., эвен.чāpй̄<як., як.cāpы
сайшаал	мо.sayisiyal, ма.sayišan
соёо	мо.soyuγ-a, ма.soyihon
суурин	мо.sayurin, ма.soorin
сүүдэр	мо.següder, ма.sebderi, нег.сэвдэлэ, ульч.шудэчэ, орок.сэдэ- [*сэвдэ<*сэбдэ], нан.шудэ [*сэвдэ<*сэбдэ]
сэрүүн	мо.serigün, ма.serguwen, эвенк.сэрун<як.<мо., ульч.сэвурули~сэурули, нан.сэр, сэргүз, як.cāpий̄н~cōpй̄н, нан.sergue<монг.
сээр	мо.seger, ма.seyige
таана	мо.tayan-a, ма.tana<мо.
ташаа	мо.tasiy-a, ма.tašan, ороch.тасара, нан.тасиаразй̄
тойрог	мо.toyuriγ, ма.tohoro
томруун	мо.tomurayun, ма.tomorohon~tomorhon
тоо	мо.toy-a, ма.ton, эвенк.тан, сол.танй̄, эвен.тан, нег.танун нан.таб
тоодог	мо.toyuduγ, ма.todo, эвенк.тбдок<мо., эвен.түддақа
тооно	мо.toyuni, ма.tonu
тоор	мо.toyur~tour~toor<хят., ма.toro<хят.
тушаал	мо.tusiyal, ма.tušan
тэмээ	мо.temege, ма.temen, эвенк.тобо<як., сол.тэмэгэ<мо., ороch.тэмэ<ма., нан.тэмэ<ма.
угсаа	мо.uysay-a, ма.uysun
улаа	мо.ulay-a, ма.ula, ороch.ули, ульч.ула
улаан	мо.ulayan, ма.fulguyan, эвенк.һулама, сол.улā, эвен.һулати, нег.холајин, нан.фолгәэ ~форгәэ
ууц	мо.uγuṣa, ма.uṣa, сол.ӯча<мо., ороch.уча~учча
уул	мо.ayula, ма.alin, эвенк.алан, эвен.альн, нег.алахит, үд.ала, нан.ала, дунш.ula
үлээ-	мо.üliye-, ма.fulgiye-, дунш.fuilieγ-, эвенк.һув-, сол.үйу-, нег.уну-уну-, ороch.ху-пу-, үд.пундэ-, ульч.пу-, орок.пу-, нан.пу-
үнээ	мо.ünigen~üniy-e, ма.uniyen, сол.униэ~унэгэ<мо., дунш.funieγүн
үрээ	мо.ürege, ма.urgešen, эвенк.ur, ороch.urica
хаа-	мо.qay-a-, ма.qa-<мо., эвенк.кā-<мо., эвен.кāj-<як., сол.кālга-~хālга-<мо.
хаан	мо.qayan, ма.han, эвенк.каγанкāн, эвен.қаγън~қаγъна, нан.кā
хайр-	мо.qayari-, ма.hari-
халаа	мо.qalay-a, ма.hala
халиун	мо.qalilyun, ма.qayilun, эвенк.калун~кал'ун<мо.
халуун	мо.qalayun, ма.halhün<мо., үд.халахај<ма.<мо., даг.xalo
хараат	мо.qarayatu, ма.haratu
хариу	мо.qariγu, ма.qaru, эвенк.харин, сол.харй̄<мо., ороch.каи[*кари-], ульч.қару(н-)~хару(н-), орок.қару(н-), нан.қарб/й̄
харуул	мо.qarayul, ма.qarul

хатуу	мо.qataγu, ма.hatan, эвенк.катан, сол.хата́, эвен.қатьγ, нег.катан, ороц.ката, ульч.хата(н-), орок.қата~қатта, нан.хата́
хичээ-хиншүү	мо.kičiyе-, ма.kičе-, эвенк.кичэ-, эвен.кичэј-, ульч.кичэ-, нан.кичэ- мо.kingsigüü, ма.kungšun
ходоод	мо.qoduyadu, ма.qodo, эвенк.кото<мо., сол.хододо<мо., ульч.қ ұта, нан.қота
хошуу	мо.qosiyu, ма.hošo, эвенк.кочо<мо., нег.кочо, үд.косо(н-)
хөвөө	мо.köbügen, ма.kubuhēn, эвенк.кувэ-<мо.
хөшүүн	мо.kösigün, ма.kušun
хууль	мо.qauli, ма.qooli, ульч.қбли, нан.қали
хүүр	мо.kegür, ма.kifur
хүрээ	мо.küriy-e, ма.kuren, эвенк.курē, эвен.кур'ē, нег.курī, орок.курэи~курэј, хам.хурэ, як.куруь
хэлхээ	мо.kelkiy-e, ма.hešen, ороц.хэсии, ульч.хэсии, нан.хэш
хэрээ	мо.keriy-e, ма.keru, эвенк.кэре<мо.
хээр	мо.keger, ма.keyire, эвенк.којор, хам.кеуер
цээж	мо.čegeji, ма.čejen<мо., эвенк.žеј in, нег.žojan
цоор	мо.čoyur, ма.čoron
чөлөө	мо.čilüge, ма.šolo, эвенк.чулэ<мо., сол.сөлб̄~сулб̄<мо.
чуулган	мо.čiyulγan, ма.čulγan, эвенк.сулган<як., эвен.чуглан<мо., як.сугулан ~ сулан
Шаазгай	мо.šayajayai, ма.saysaha
шилүүс	мо.silügüsü, ма.silun
шууд	мо.siyud, ма.šuwe, эвенк.шепту
шуурга	мо.siyury-a, ма.šurya<мо.
шүүс	мо.šigüsü, ма.šusu, эвенк.чүксэ, сол.сүрчэ, эвен.чүс, ороц.чүксэ, орок.сүклэ~түксэ, нег.чүксэ
эмээл	мо.emegel, ма.enggetu, эвенк.эмэүэлэ, сол.эмэгэ л, орок.эмэ(н-)-эмэүэ(н-)
эрүү	мо.eregüü, ма.erun, эвенк.егү, сол.егү, ульч.эрүлэ, нан.егү
язгуур	мо.iγayur, ма.fujuri
ямаа	мо.imay-a, ма.niman, эвенк.инаγан, сол.имаγа, нег.имага, ороц.има, үд.има, ульч.има(н-), нан.има
янцгаа-ятуу	мо.inčay-a-, ма.inča- мо.itayu, ма.itu, сол.ичау<мо.

Манж, монгол хэлэнд язгуур дүйх эдгээр үгсийг урт эгшгийг тэмдэглэсэн байдлаар нь доорх хэдэн зүйлд хувааж болох байна.

1. Орчин цагийн монгол хэлний үүсмэл урт эгшгийг тэмдэглэсэн монгол бичгийн "эгшиг-гийгүүлэгч-эгшиг" /NCVI цогц манж бичгийн хэлэнд дан эгшигтэй дүйцэх нь.

Томьёолбол: мо.VCV = ма.V

1.1. "VCV" цогцдоо "γ/g" гийгүүлэгч бүхий үгс

ayula – alin	toyuduy – todo	bayičay-a - baiča-	obuy-a – obo
bayatur – baturu	toyunu – tonu	baray-a – baran	temege – temen
boyudul – bofon	uyuča – uča	bitegüü – butu	ulay-a – ula
buγurul – burulu	qay-a - qa-	boljuy-a – boljon	uγsay-a – uγsun
dayari- - dari-	qayan – han	buday-a – buda	qalay-a – hala
degeji – deji	qayari- - hari-	buruyula- - burula-	qatay-u – hatan
jayar/jiyar – jarin	čegeji – čejen	büdügün – bedun	qaliyun – qayilun
jeger-e – jeren	čoyur – čoron	yačay-a – yašan	qarayatu – haratu
jegerde – jerde	čiyulγan – čulγan	yutuy-a - yutu-	qariyu – qaru
oyunu – onon	siyud – šuwe	degege – dehe	qarayul – qarul
sayari – sarin	siyury-a – šurya	jiruy-a – juran	kingsigüü– kungšun
tayan-a – tana	sigüsü – šüšü	jögege- - juwe-	qosiyu – hošo
toy-a – ton	aduyu – adun	ilegüü – fulu	kösigün – kušun

čilüge – šolo
silügüsü – silun
eregüü – erun

imay-a – niman
inčay-a- - inča-
itayu - itu

mayalingyu–
malangyu
ijayur – fuјuri

1.2. “VCV” цогцдоо “у” гийгүүлэгч бүхий үгс

büriy-e – buren
kičiyе- - kiče-
küriy-e – kuren

keriy-e – kerü
büliyen – buluqan
јabsiyaн – јabšan

sayisiyal – sayišan
rasiyan – arašan
tasiy-a – tašan

tusiyaI – tušan

Монгол хэлний урт эгшигтэй дүйцэх манж бичгийн хэлний дан эгшгийг уртаар дуудаж байсан бололтой. Л. Мишиг гуай “Манж хэлэнд урт эгшгийг тэмдэглэх нь нэлээд бэрхшээлтэй учраас урт “аа, ий, ээ, үү”-г ерийн богино “а, э, и, ү”-ээр тэмдэглэж бичээд уртаар дуудаж байсан зүйл үзэгдэнэ”⁸ гэж бичсэн бол И. Захаров “u”-г урт дууддаг”⁹ гэж үзсэн байдаг. Манжийн дусал бинттэй үсгийн бичигт богино эгшиг бүхий үгийг дусал бинтгүй үсгийн бичигт уртаар тэмдэглэсэн зүйл байна¹⁰.

Дусал бинттэй үсгийн бичигт	Дусал бинтгүй үсгийн бичигт	ᠠᠠ	ᠠᠠᠠ
ᠠᠠᠨ	ᠠᠠᠨᠠ	ᠠᠠᠨ	ᠠᠠᠨᠠ
ᠠᠢ	ᠠᠢᠨ · ᠠᠢ	ᠠᠢᠨ	ᠠᠢᠨᠠ · ᠠᠢᠨ
ᠠᠶ	ᠠᠶᠠᠨ · ᠠᠶ	ᠠᠶᠠᠨ	ᠠᠶᠠᠨᠠ · ᠠᠶᠠᠨ

Энэ хоёр бичгийн аль алинд эгшиг, урт богиноор холилдон тохиолдож буй нь зарим аялгуунд урт, богино эгшиг тохирдгийн баримт биз ээ. Бас дусал бинттэй үсгийн бичигт “ombi, ome” /бол-/ хэмээх үгийг “oombi, oome” гэж тэмдэглэсэн нь буй.

Өнөөгийн туркмен, якут, чуваш, эвенк, эвен, негидал, ороки, нанай, ламут зэрэг алтай язгуурын төрөл хэлнүүдэд өвөг алтай хэлний үеэс уламжилж ирсэн анхдагч урт эгшгийн ул мөр байгаа нь нэгэнт тодорхой болсон. Тэгвэл манж хэлэнд ч мөн анхдагч урт эгшиг байж болох нь онолын үүднээс саадгүй. Тиймээс дусал бинтгүй үсгийн бичигт уртаар тэмдэглэгдсэн ч дусал бинттэй үсгийн бичигт богино эгшиг бүхий дээрх үсгийг анхдагч урт эгшиг хадгалсан гэж үзэж байна.

2. Монгол хэлний “VCV” цогц манжид “эгшиг-эгшиг” хэлбэртэй дүйцэх нь. мо.VCV = ма.VV

2.1. VCV цогц нь хоёр өөр эгшигтэй тохирно: gegüü – geu, degüü – deu, negü- - neu-

Авианы түүхэн хөгжлийн явцад утга ялгах өргөлттэй эгшиг урт эгшгийн шинжтэй болсноор “VCV” цогц дахь гийгүүлэгч сулран суларсаар аажимдаа сугараад сул шүргэх гийгүүлэгчийн өмнөх богино эгшиг арынхаа урт эгшигтэй ухран ижилшиж амжаагүй байсан тэр үед эдгээр үгс монгол хэлнээс манж хэлэнд оржээ.

2.2. Адил хоёр эгшигтэй тохирно: qauli <*qayuli – qooli, sayurin - soorin

*qayūli > *qayūli > *qawūli > qa'ūli > qo'ūli > qu'ūli > qūli'

*sayūrin > *sayūrin > *sawūrin > *sa'ūrin > *so'ūrin > su'ūrin > sūrin хэмээн сэргээж үзвэл сугарсан гийгүүлэгчийн өмнөх эгшиг ухран ижилшиж байсан тэр үед манж хэлэнд орсон бололтой.

⁸ Л. Мишиг, *Манжийн дусал бинтгүй үсгийн бичгийн тухай*, МУИС, ЭШБ VII б., 1964.

⁹ И. Захаров, *Грамматика маньчжурского языка*, Санктпетербург, 1879.

¹⁰ *Tongki fuqa aqū hergen-i bithe*, Corpus Scriptorum Mongolorum V, Улаанбаатар, 1959.

Ингэж хоёр адил болоод өөр эгшгээр тэмдэглэгдсэн нь монгол хэлний урт эгшиг бүрэлдэн бий болохдоо туулсан улирал хувьслын нэгэн үеийг хадгалан үлджээ. Эдгээр үгс нь судлаачдын "keiken, teike, taulai" зэрэг онцгой бичлэгтэй үгс нь хоёр өөр эгшгийн хоорондох гийгүүлэгчийн сугарлыг шууд тусган тэмдэглэснээс үүдэлтэй, улмаар монгол бичгийн зөв бичих зүйд хэвшин тогтсон хэлбэр хэмээн дурдсантай¹ нийцэх манж бичгийн хэлний баримт болно.

2.3. "VCV" цогц нь хос эгшигтэй тохирно: keger – keyire, seger – seyire, nege- - nei-

"ei" буюу уртархаг хос эгшгээр тэмдэглэсэн нь ямартаа ч ерийн нэг богино "e"-ээс өөрөөр дуудагдахыг үзүүлсэн хэрэг биз ээ. Урт "a,e"-г урт "o,u" эгшиг шиг шүд давхарлан бичих боломжгүй учраас "i" эгшгээр урт дуудах ёстойг харуулсан байх. Үүний адил жишээ дусал бинтгүй үгсийн бичигт буй.

Дусал бинтэй үгсийн бичигт	Дусал бинтгүй үгсийн бичигт		
ai	ai~a	bai	bai ~ ba
cai	cai~ca	baibi	babi
		ba	ba~bai

Эндээс үзвэл уртархаг хос эгшиг болон дан эгшгээр тэмдэглэснээ аль алийг уртаар дуудаж байсан бололтой.

Монгол хэлний үгийн эхний, мөн хэлний үзүүрийн гийгүүлэгч болон зарим хэлний үгийн гийгүүлэгчийн дараа орсон "э" эгшиг нь манж хэлний нийлмэл эгшиг "ai, ei"-тэй тохирно. Жишээ нь: mo.er-e – ma.air /эр/, mo.kebis – ma.keibisu /хивс/, mo.seger – ma.seire /сээр/, mo.nege- - ma.nei- /нээх/, mo.egeci – ma.aigeci /эгч/ г.м

3. Хоёр хэлэнд адилхан "эгшиг-гийгүүлэгч-эгшиг" хэлбэртэй дүйцэх нь. mo.VCV = ma.VCV

ayali – ageli	dabayan – dabayan	aḱiy-a – aḱiha	yasiyun – yosihon
toyuriy- tohoro	soyuy-a – soyihon	gūjige – gūwejihe	deligūü(n)–delihun
köbüge(n) – kubuhen	begere- - beyere-	ūniy-e(n) – uniyen	kegür - kifur

4. Монгол хэлний "VCV" цогц манж хэлэнд "гийгүүлэгч-эгшиг" хэлбэртэй дүйцэх нь. mo.VCV = ma.CV

aray-a – aryan	bergen < *berigen – berhu	jiluy-a – jilhū	ürege – urgešen
qalayun – halhūn	tomurayun – tomorhon	görügesü – gurgu	iniye- - inje-
serigün – serguwen			

Эдгээр манж үгсийн хоёрдугаар үеийн богино эгшиг гээгдэж өмнөх гийгүүлэгчээ дэвсгэр болгосон байдалтай байна. Учир нь өргөлттэй холбоотой бөгөөд өргөлтгүй дэд үеийн богино эгшиг балархайшиж эцэстээ сугарснаар тайлбарлагдана. Гийгүүлэгчийн дараах эгшиг урт тул өмнөх балархайшсан эгшиг гээгдэх боломж гийгүүлэгчийнхээс илүү юм.

Ер нь манж хэлэнд үгийн дэд үед орсон богино эгшиг гээгдсэн үзэгдэл нэлээд байна. Жишээ нь: ma.nomhon – mo.nomuqan /номхон/, ma.nayḱu – mo.nayayḱu /нагац/, ma.olhu – mo.oluyai /олгой/, ma.moyto – mo.moyutur /моготор/ г.м

Ялангуяа ярианы хэлэнд гээгдэх нь нэн тогтвортой. Жишээ нь:

бич.ufarambi – яр.uf'arme /алдах/,	бич.aniyalambi – яр.a'nialme /шинэлэх/,
бич.buleku – яр.bülko /толь/,	бич.adaname – яр.adna'me /оролцох/,
бич.afambi – яр.a'vme /байлдах/,	бич.aḱabumbi – яр.a'tsbume /нийлүүлэх/,
бич.ulebumbi – яр.ulbume /идүүлэх/ г.м	

¹ Д.Заяабаатар, Сонгодог бичгийн хэлний өмнөх үеийн дурсгалууд монгол хэлний түүхэн хөгжлийн баримт болох нь, Acta Mongolica, Vol.4 (236), Улаанбаатар, 2005.

5. Монгол хэлний "VCV" цогц манж хэлэнд "giya/giye" хэлбэртэй дүйцэх нь.

ulayan – fulgiyan
ноуууан - niowanggiyan

büriyesü(n) – burgiyen
üliye- - fulgiye-

gegen/gegegen – genggiyen

Дээрх манж үгсийн сүүлчийн үеийн эгшгийн байдал нь эгшгийн уртыг дан эгшгээр болон уртархаг хосын байдлаар тэмдэглэдгээс ялгаатай, илүү уртаар дуудах ёстойг үзүүлжээ. Мөн "g" гийгүүлэгчийн арын эгшиг нь монгол хэлний шүргэх "γ/g" болон "y"-ийн дараах эгшигтэй тохирч байгаа нь утга ялгах өргөлтөөс урт эгшиг үүсэж улмаар гийгүүлэгч суларсаар сугарсан хэмээн үүсмэл урт эгшгийн үүсэл гарлыг тайлбарласныг нотлох манж хэлэн дэх жишээ болох юм.

Монгол хэлний шүргэх "γ/g" сугарсан байхад манж хэлний "g" яагаад сугарсангүй вэ гэх асуудал гарч ирнэ. Манж хэлний тэргүүн үе монгол хэлнийхээс харьцангуй уртаар дуудагддаг. "g"-ийн дараах эгшиг нь бүр ч илүү урт учраас хоёрдугаар үеийн богино балархайшсан эгшгийн гээгдэх боломж "g" сугарахаас илүү ажээ. Иймийн тул, дэвсгэр гийгүүлэгчийн дараа орох болсон "g" гийгүүлэгч сугарах нөхцөл бололцоо бүрдэхгүй нь тодорхой.

Сүүлийн үед зарим судлаач монгол бичгийн хэлний урт эгшгийг тэмдэглэсэн "V(γ/g)V" бүтэц дэх „γ,g“ зэрэг гийгүүлэгч нь авианы байрлалаас үүдэн нэмэн жийрэглэсэн, цэвэр зөв бичих зүйн холбогдол төдий бичлэг гэсэн санал дэвшүүлсэн билээ.² Үүнд манж хэлний дээрх баримт эсрэг нотолгоо болж байна.

Эцэст дүгнэхэд, манж бичгийн хэл нь урт эгшгийг тэмдэглэх өөрийн гэсэн өвөрмөц зүй тогтолтой бөгөөд алтай овгийн зарим хэлний нэгэн адил анхдагч урт эгшигтэй. Манж хэлний анхдагч урт эгшиг нь үгийн эхэн, дунд, адагт аль алинд тохиолдох ба дусал бинтгүй үсгийн бичгийн дурсгалд тэмдэглэгдэн үлджээ. Тэрхүү анхдагч урт эгшгийг дан эгшгээр тэмдэглээд урт ба богиноор дууддаг байсан.

Монгол хэлнээс манж хэлэнд хожуу үед орсон үгсийн хэлбэр дэх үүсмэл урт эгшгийг манж бичигт ихэвчлэн дуудлагад ойртуулан сугарсан гийгүүлэгчгүйгээр өөрийн хэлний анхдагч урт эгшгийг тэмдэглэдгийн нэгэн адил дан эгшгээр тэмдэглэжээ.

Монгол хэлний үүсмэл урт эгшгийн "VCV" цогц дахь хоёрдугаар эгшиг нь уртаар дуудагдаж байсан зүй тогтол манж хэлэнд ч мөн ямар нэг хэмжээгээр байсан гэж болох байна. Гэвч манж хэлний хоёрдугаар үеийн балархай эгшиг ихэвчлэн гээгддэг тул түүний дэргэдэх "h/g" зэрэг гийгүүлэгч сугарах орчин, нөхцөл бүрдэл болсонгүй.

² Ж. Санжаа, *Монгол бичгийн хэлний урт эгшгийн үүсэл гарлын тухай шинэлэг санал*, Монгол Судлалын эрдэм шинжилгээний бичиг, боть XVI(160), Улаанбаатар, 2000.

АШИГЛАСАН НОМ

- Баярсайхан М., *Манж бичгийн хөгжлийн зарим асуудалд*, Монгол Судлалын эрдэм шинжилгээний бичиг, боть XVI(160), УБ., 2000.
- Баярсайхан М., Отгонтуул Д., *Монгол манж үгийн толь*, УБ., 1995.
- Захаров И., *Грамматика маньчжурского языка*, Санктпетербург, 1879.
- Заяабаатар Д., *Сонгодог бичгийн хэлний өмнөх үеийн дурсгалууд монгол хэлний түүхэн хөгжлийн баримт болох нь*, Acta Mongolica, Vol.4 (236), УБ., 2005.
- Лувсанвандан Ш., *Монгол хэлний авиазүйн онол практикийн асуудлууд*, УБ., 2002.
- Мижиддорж Г., *Манж-монгол ижил язгууртай үгсийн толь бичиг*, Хэл зохиол, УБ., 1964.
- Мишиг Л., Шархүү Ц., *Манж - монгол үгийн толь*, УБ., 1966.
- Мишиг Л., *Манжийн Дусал бинтгүй үгсийн бичгийн тухай*, МУИС, ЭШБ, УБ., 1964.
- Поппе Н., *Алтай хэл шинжлэлийн удиртгал*, УБ., 1999.
- Ринчен Б., *Монгол ард улсын хамниган аялгуу*, УБ., 1969.
- Санжаа Ж., *Монгол бичгийн хэлний урт эгшгийн үүсэл гарлын тухай шинэлэг санал*, Монгол Судлалын эрдэм шинжилгээний бичиг, боть XVI(160), УБ., 2000.
- Төмөртөг Д., *Монгол хэлний түүхэн хэл зүй*, УБ., 1992.
- Цинциус В. И., *Сравнительный словарь тунгусо - маньчжурских языков*, Ленинград, 1975.
- Цог О., *Монгол манж ижил язгуурт үгсийн эгшгийн тохиролцооны тухай*, Үндэстэний сэтгүүл, V, Хөххот, 1988.
- Энхбат, *Манж ярианы хэлний үгсийн авиа товчлогдох тухай*, ӨМИС, ЭШС, III, 1992.

Poppe N., *Jurchen and Mongolian*,

Poppe N., *On the long vowels in common Mongolian*, Helsinki, 1967.

Sergei Starostin, Anna Dybo, Oleg, Mudrak, *Etymological Dictionary of the Altaic languages*, Neiderland, 2003.

сеҗенҗоу, *mongyol üges-ün iǰayur-un toli*, jan jiy-a, 1988.

Tongki fuqa aqı hergen-i bithe, Corpus Scriptorum Mongolorum V, УБ., 1959.